



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/212

Мандалговь

“Уаз Мега” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/185 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Эрдэнэдалай сумын ЕБС-ын албан хэрэгцээнд автомашин” нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Уаз Мега” ХХК-тай 35,500,000 (гучин таван сая таван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу “Эрдэнэдалай сумын ЕБС-ын албан хэрэгцээнд автомашин” нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Уаз Мега” ХХК-ийн захирал (Д.Мягмарсүрэн)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Эрдэнэдалай сумын Засаг дарга (С.Мөнхбаатар), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060829